



The AMERICAN CHAMBER of Commerce in Mongolia

**Хэвлэлийн мэдээ
29.09.2020**

**Холбоо барих
+976 9511 7771**

АмЧам Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г. Ёндонтой уулзалт зохион байгууллаа

УЛААНБААТАР, Монгол улс – Монгол дахь Америкийн Худалдааны Танхимын (АмЧам Монгол) 9-р сарын уулзалт “Уул уурхайн салбарын бодлого: 2020-2024” сэдвээр 2020 оны 9-р сарын 29-ны Мягмар гарагт Шангри-Ла зочид буудалд боллоо. Уулзалтад АмЧамын гишүүн байгууллагууд, гадаадын болон үндэсний хөрөнгө оруулагчид, элчин сайдын яамд болон гадаадын худалдааны танхимын төлөөлөл оролцлоо.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд Г. Ёндон хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх, баялгийн сан байгуулах арга зам, уул уурхайг дагасан төмөр замын зэрэг томоохон бүтээн байгуулалтын ач холбогдол, хөрөнгө оруулалтыг хэрхэн татах зэрэг асуудлаар мэдээлэл хийж, гадаадын хөрөнгө оруулагчидтай санал солилцож, асуулт, хариултын хэлэлцүүлэг хийлээ.

2020 оны УИХ-ын сонгуулийн үр дүнд шинээр байгуулагдсан Монгол Улсын Засгийн газар 2020-2024 онд хэрэгжүүлэх мөрийн хөтөлбөрөө боловсруулж УИХ-аар батлуулаад удаагүй байгаа энэ цаг үед АмЧам Монгол нь ач холбогдолтой сэдвээр тус уулзалтыг зохион байгууллаа.

Сайд Г. Ёндон онцолж хэлэхдээ, "Манай салбар гадаадын хөрөнгө оруулалтаас ихээхэн хамаардаг. Монгол Улс, монголчуудад итгэх хөрөнгө оруулагчдын итгэлийг сэргээж, бэхжүүлэх, харилцан ашигтай хамтын үйл ажиллагааг улам бүр гүнзгийрүүлэн хөгжүүлэхийг зорино. Иймээс уул уурхай, хүнд үйлдвэрийн салбарт хөрөнгө оруулалтыг татах, харилцан үр ашигтай төсөл, хөтөлбөрийг гадаад, дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран хэрэгжүүлж, хариуцлагатай, ил тод уул уурхайг хөгжүүлэх зорилтыг тавин ажиллаж байна," гэв.

Ил тод, хариуцлагатай уул уурхай, нэмүү өртөг шингэсэн үйлдвэрлэлийг хөгжүүлж, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгож, баялгийн шударга хуваарилалтын зарчмыг хэрэгжүүлнэ гэсэн тэргүүлэх зорилтыг үйл ажиллагааны хөтөлбөрт дэвшүүлсэн бөгөөд энэ зорилтыг бодитоор хэрэгжүүлэхэд анхаарал тавин ажиллаж байна гэж онцлон тэмдэглэв.

АмЧам Монголын ТУЗ-ийн дэд дарга Н.Мөнхнасан нээлтийн үгэндээ, "АмЧам Монголын гишүүн компаниуд нь Монголын уул уурхайн салбар дахь гол хөрөнгө оруулагч, нийлүүлэгч нар билээ. Гишүүдийн сайн туршлага, амжилтыг танилцуулах, хуваалцах байдлаар Монголд өрсөлдөх чадвартай, хариуцлагатай уул уурхайн салбарыг хөгжүүлэхэд бид дэмжлэг үзүүлж, Уул уурхай, дэд бүтэц, хүнд үйлдвэрийн салбарын хороогоор дамжуулан, Монгол Улсын засгийн газартай хамтран ажиллахад бэлэн байна" гэв.

Мөнхнасан дарга үргэлжлүүлж хэлэхдээ, хувийн хэвшилд тулгуурласан нээлттэй, өрсөлдөх чадвар бүхий хариуцлагатай уул уурхайн салбар нь улс орны хөгжлийн асуудлыг шийдвэрлэхэд ач холбогдолтойг онцлон тэмдэглэж уул уурхайн салбарын талаарх үнэн зөв, бодитой мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх нь чухал гэж онцлов.

АмЧамын Монголын тухай

www.amcham.mn

АмЧам Монгол нь АНУ-Монгол Улс хоорондын бизнесийн түншлэлийг өргөжүүлэх, бэхжүүлэх, эрх ашгийг нь хамгаалах болон Америкийн хөрөнгө оруулалтыг Монголд татах чиглэлээр ажилладаг бие даасан, гишүүддээ үйлчлэх төрийн бус байгууллага юм. АмЧам Монгол нь 3 сая гаруй гишүүдтэй дэлхийн хамгийн том бизнесийн холбоонд тооцогддог Америкийн Худалдааны Танхимын албан ёсны салбар юм. Мөн АмЧам Монгол нь Ази Номхон далайн 29 орнуудын Америкийн худалдааны танхимуудыг нэгтгэдэг Ази Номхон далайн орнуудын Америкийн Худалдааны Танхимуудын Зөвлөл байгууллагын гишүүн юм.